



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/17

Эг

**Чонын үргээлгэ зохион байгуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5, 28.1, 35.1 дэх заалтыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Онон багийн нутаг Цагаан горхи, Тулгат, Живхээстэй, Ёл, Арангатай, Нүүргэстэй зэрэг газруудад чонын тоо толгой олширч, мал болон малчны хот руу удаа дараа халдаж хорогдол учруулж байгаа тул 2025 оны 02 дугаар сарын 18-наас 03 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд чонын үргээлгэ зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Үргээлэгт иргэд, малчдыг идэвх, зохион байгуулалт сайтай хамруулан оролцуулж, галт зэвсэгтэй аюулгүй харьцах талаар заавар зөвлөгөө өгч ажиллахыг сумын цагдаа, дэд ахлагч (Б.Мөнгөнтөгс), Онон багийн Засаг дарга (Д. Хонгорзул) нарт үүрэг болгосугай.

3. Үргээлгийг зохион байгуулах явцад чоноос бусад ан амьтан авлахгүй байх ба чоно авласан тохиолдолд Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид мэдэгдэж, зөвшөөрлийн бичгийг хуулийн дагуу авахыг анчдад сонордуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ

232501098